



07/12/15

НИЙСЛЭЛИЙН АУДИТЫН ГАЗАР  
АКТ

2015 оны 03 сарын 23 өдөр

Дугаар НАТ-АУ-2015/СН-11-4-02 Улаанбаатар хот

ТӨСВИЙН ОРЛОГО БОЛГОХ ТУХАЙ

Төсвийн тухай хуулийн 8.9.3, Төрийн Аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлд тодорхойлсон Нийслэлийн Аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Баянгол дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2014 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд аудит хийхэд дараах зөрчил илэрлээ. Үүнд:

- Гар утасны хэрэглээний зардлыг 701.9 мянган төгрөгөөр илүү зарцуулсан нь Монгол Улсын Засгийн газрын 2002 оны 120 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт 1.2-д "Албан ажлын хэрэгцээний гар утас хэрэглэх эрх бүхий албан тушаалтан 130 мянган төгрөгөөс илүүгүй үнэтэй гар утас хэрэглэх бөгөөд гар утасны сарын нийт хэрэглээний зардал 65 мянган төгрөгт багтана" тогтоосоныг хэрэгжүүлж ажиллаагүй;
- Хоол хүнсний үнэд 237.2 мянган төгрөг зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 6.4.1. "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" заалтыг зөрчсөн;
- Иргэдийн төлөөлөгчдийн хурлын даргын гадаад томилолтын зардлыг еврогоор тооцож 3,676.5 мянган төгрөг илүү олгосон нь Сангийн сайдын 2011 оны 188 тоот "Гадаад томилолтын зардлын хэмжээг шинэчлэн батлах тухай" тушаалын хавсралтад заасан зардлыг доллараар тооцож олгох заалтыг зөрчсөн; 1,1.
- Хувь хүмүүсээр ажил үйлчилгээ гүйцэтгүүлж олгосон ажлын хөлснөөс нийт 470.0 мянган төгрөгийн тэтгэвэр суутгаагүй нь Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 12.1. "Үйл ажиллагааны орлогод хуулийн этгээд байгуулахгүйгээр бие даан мэргэжлийн үйлчилгээ, үйлдвэрлэл, арилжаа эрхэлж олсон дараахь орлогыг хамруулна: 12.1.2. " хувиараа ажил гүйцэтгэх, бүтээгдэхүүн үйлдвэрлэх, борлуулах, үйлчилгээ үзүүлэх зэргээр олсон үйлдвэрлэл, арилжааны орлого." заалтуудыг зөрчсөн;
- Төсвөөс Иргэдийн төлөөлөгчдийн хурлын дарга Д.Дэлгэрбатын "Мандах бүртгэл" дээд сургуулийн 2,900.0 мянган төгрөгийн сургалтын төлбөрийг

төлсөн нь Засгийн газрын 2014 оны 147 дугаар тогтоолын 2) " улсын төсвийн татаас, орон нутгийн төсвийн урсгал зардлыг 20-иос доошгүй хувиар бууруулах;" , Засгийн газрын 218 дугаар тогтоолын 29. "Төрийн албан хаагчийг 90 хүртэл хоногийн хугацаагаар эрх бүхий байгууллагын шийдвэрийн дагуу "төрийн хөрөнгө"-өөр давтан сургах, мэргэжлийг нь дээшлүүлэхэд түүний эрхэлж байгаа албан тушаалын цалинг олгоно" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15.1.12 "аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих..." Монгол Улсын Ерөнхий аудиторын 2009 оны 47 тоот тушаалаар баталсан "Төлбөрийн акт тавих, албан шаардлага өгөхөд баримтлах журам"-ын 2.1.1.9 "... төлбөрийн акт тавих үндэслэлтэй бусад нөхцөл байдал гаргасан" заалтыг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Дээрх зөрчлийн 7,985.6 мянган төгрөгийг холбогдох албан тушаалтнуудаар нөхөн төлүүлж Нийслэлийн төсөвт төвлөрүүлэхээр төлбөрийн акт тогтоосугай.

2. Төлбөрийн 7,985.6 мянган төгрөгийг Нийслэлийн санхүү, төрийн сангийн хэлтэс, Төрийн сан банк дахь 200000955 тоот дансанд 2015 оны 5 дугаар сарын 30-ны дотор төлж барагдуулан, холбогдох тооцоо хийхийг Баянгол дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын нарийн бичгийн дарга П.Цэцэгмаа, нягтлан бодогч Б.Батзаям нарт хариуцуулсугай.

Дээрх төлбөрийг барагдуулаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28.2. "Дараах тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ:" 28.2.1. "аудитад хамрагдсан байгууллагын санхүүгийн тайланд төрийн аудитын байгууллагаас санал, дүгнэлт өгөх боломжгүй тохиолдолд" 28.2.2. "төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд." заалтын дагуу холбогдох арга хэмжээ авах болно.

**ТОГТООСОН:**

САНХҮҮГИЙН АУДИТЫН II АЛБАНЫ  
АХЛАХ АУДИТОР  
И.ЭРДЭНЭЦЭЦЭГ



**АКТЫГ**

**ЗӨВШӨӨРСӨН:**

БАЯНГОЛ ДҮҮРГИЙН ИРГЭДИЙН  
ХУРЛЫН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА  
П.ЦЭЦЭГМАА  
НЯГТЛАН БОДОГЧ  
Б.БАТЗАЯА

**ХЯНАСАН:**

НИЙСЛЭЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ДЭД ДАРГА

САНХҮҮГИЙН АУДИТЫН II  
АЛБАНЫ МЕНЕЖЕР

Т.САРАНТУЯА

Ц.ХОСЖАРГАЛ







07/118

НИЙСЛЭЛИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2015 оны 05 сарын 23 өдөр

Дугаар НАГ-АХ-12015/-АН-Б-4-02

Улаанбаатар хот

ЗӨРЧИЛ АРИЛГУУЛАХ ТУХАЙ

Төсвийн тухай хуулийн 8.9.3, Төрийн Аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлд тодорхойлсон Нийслэлийн Аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Баянгол дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2014 оны жилийн эцсийн санхүүгийн нэгдсэн тайланд аудит хийхэд дараах зөрчил илэрлээ. Үүнд:

- Анхан шатны бүрдэл дутуу баримтаар Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардлаас 6,500.0 мянга, Иргэдийн төлөөлөгчдийн хурлын зардлаас гадаад томилолтын зардалд 57,629.4 мянга, нийт 64,129.4 мянган төгрөгийн гүйлгээ хийсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.1.7. "анхан шатны баримт бүрдүүлээгүй, заавал хөтлөх ёстой журнал, ерөнхий дэвтэр, дэлгэрэнгүй бүртгэлийн дэвтрийг хөтлөөгүй байх" заалтыг зөрчсөн;
- Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардлын батлагдсан төсвийн 34.0 хувь буюу 8,124.0 мянган төгрөгөөр хөрөнгө бэлгэсэн нь Төсвийн тухай хуулийн 16.5.5. "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" заалтыг зөрчсөн;
- Тайлант онд баяр наадам, хүлээн авалт, уулзалт, сургалт, вип үйлчилгээ, гадаад дотоод томилолтын бэлэг дурсгал, төрийн одон медаль авсан хүнд өндөр үнэтэй бэлэг дурсгалын зүйл авч өгсөн зэрэг зардалд нийт 64,741.5 мянган төгрөгийг зарцуулсан нь Засгийн газрын 2014 оны 147 тоот "Төсвийн хэмнэлтийн горимд шилжүүлэх зарим арга хэмжээний тухай"-ын тогтоолын 4. "Яам, агентлаг, төсөвт байгууллагууд төв, орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан төсвийн хөрөнгөөр олон нийтэд зайлшгүй мэдээлэх хууль тогтоомж, албан ёсны шийдвэр болон тэдгээрийн хэрэгжилтийг сурталчлан таниулахаас бусад зорилгоор өөрийн байгууллага, хамт олныг рекламдах, телевизийн шоу уралдаан, тэмцээн зохион байгуулах, цуврал олон ангит кино хийхгүй бөгөөд баяр ёслол, байгууллага, салбарын ой, тэмдэглэлт өдөр зохион байгуулахтай холбогдуулан төсвийн хөрөнгөөр цаасан мэндчилгээ илгээх, бэлэг дурсгалын зүйлс, цүнх, календарь зэрэг зүйлс бэлтгэх, ивээн тэтгэхийг хориглосугай". заалтыг зөрчсөн;

- Дотоод томилолтын зардал батлагдаагүй байхад 19,666.7 мянган төгрөгийн зардал гаргасан;
- Ажлын хэрэгцээний автомашин хэрэглэх эрх бүхий албан тушаалтнууд тээвэр шатахууны зардлын нормативыг 3,123.8 мянган төгрөгөөр хэтрүүлсэн байна.

Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2009 оны 47 дугаар тушаалаар батлагдсан "Төлбөрийн акт тавих, албан шаардлага өгөхөд баримтлах журам"-ын 3.1.1-ийн "Төрийн аудитын байгууллагаас гүйцэтгэж байгаа аудитын дүнд шалгагдагч байгууллагын удирдлагаас тодорхой арга хэмжээг богино хугацаанд авч хэрэгжүүлэх нь тухайн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байхад чухал үр нөлөөтэй гэж үзсэн дараах алдаа зөрчлийг арилгуулахаар төрийн аудитын байгууллага холбогдох албан тушаалтанд албан шаардлага өгнө" гэсэн заалтыг үндэслэн **ШААРДАХ НЬ:**

- Төсвийн хөрөнгийг үр ашиггүй, зориулалт бус зарцуулсан зөрчлийг дахин давтан гаргахгүй байх
- Анхан шатны бүрдэл дутуу баримтаар гүйлгээ хийхгүй байх, томилолтын тайланг тухай бүрт нь тайлагнуулж авах
- Төсвийн хуваарийг батлуулахдаа зардлын зүйл ангиар нь салгаж баталж байх /Дотоод томилолтын зардал/

Дээрх зөрчлийг цаашид давтан гаргахгүй байх, ажилдаа хариуцлагагүй хандсан холбогдох албан тушаалтнуудад хариуцлага тооцож Нийслэлийн Аудитын газарт 2015 оны 05 дугаар сарын 30-ны дотор мэдэгдэхийг шаардаж байна.

### АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН :

САНХҮҮГИЙН АУДИТЫН II АЛБАНЫ  
АХЛАХ АУДИТОР  
АХЛАХ АУДИТОР

И.ЭРДЭНЭЦЭЦЭГ  
В.ЭРДЭНЭЦОГТ

### ХЯНАСАН:

НИЙСЛЭЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ДЭД ДАРГА

Т.САРАНТУЯА

САНХҮҮГИЙН АУДИТЫН II АЛБАНЫ  
МЕНЕЖЕР



Ц.ХОСЖАРГАЛ